

Вируст гепатит өвчинтэй тэмцэх сэргийлэх

арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Улсын хэмжээнд эхний 9 сарын байдлаар Вируст гепатит өвчний 8138 тохиолдол бүртгэгдэж, 10000 хvн амд 29.3ногдож байна. Овчлол онгорсон оны мон veийнхээс 4635 тохиолдол, 10000 хvн амд ногдох овчлол 16.5-аар нэмэгдсэн байна.

Вируст гепатит өвчнийг бүтцийн хувьд авч үзвэл: цочмог А гепатит - 90.6 хувь, цочмог В гепатит- 6.7, цочмог С гепатит 1.2 хувь, бусад цочмог гепатит -1.5 хувийг тустус эзэлж байна. Цочмог А гепатит Баян-Олгий, Сүхбаатар аймгаас бусад бүх аймаг, хотод онгорсон оны мон veийнхээс нэмэгдсэн байна.

Улаанбаатар хотод энэ 9 дүгээр сард вируст гепатит өвчний 523 тохиолдол бүртгэгдэж, 2011 оны эхний 9 сарын байдлаар 2537 тохиолдол бүртгэгдээд байна. Нийт овчлолийн 2053 (80.9%) нь цочмог гепатит А, 311 (12.2%) нь цочмог гепатит В, 52 (2.1%) нь цочмог гепатит С, 121 (4.8%) нь бусад гепатитааровчилсон байна. Нийт гепатит овчлолийн дотор цочмог А гепатитийн овчлолдийлэнх хувийг эзэлж байна. Насны бүтцийн хувьд 0-14 насны хvүхдэд зонхилон тохиолдож байна. Овчлолийн 68.9%-ийг бага насны хvүхэд эзэлж байна.

Хөвсгөл аймагт 2011 оны эхний 9 сарын байдлаар бүртгэгдсэн нийт 1252 тохиолдлынхалдварт өвчний 47,7 хувийг вируст гепатитийн овчлол эзэлж байгаа богоод нийт гепатитын овчлолийн 45,4 хувь нь А хүрээний вирусээр үүсгэгдсэн байна.

Өвөрхангай аймагт 2011 оны 9 сарын байдлаар вируст гепатитийн 503 тохиолдол бүртгэгдсэн байна. Овчлолийн газар зvйн байршлаар авч үзвэл Гучин-Ус, Тогрог, Олзийт, Арвайхээр, Уянга зэрэг сумдаас голомтлон гарч, овчлолийн голомтын индексийг сумдаар авч үзвэл Гучин-Ус 2.1, Тогрог 2,0 Уянга 2.2, Бат-Олзий, Баянгол, Нарийнтээл, Арвайхээр сумдад 1.5 байна.

Дээрх байдалд дүгнэлт хийж бvх аймаг, нийслэлийн холбогдох газруудад ХОСҮТ-оос урьд нь хvргvүлсэн дараах зовломжийн хэрэгжилтийг дvгнэж, цаашид эрчимжvүлэх шаардлагатай байна.

Хэрэгжvүлэх арга хэмжээний зөвлөмж □ □

Аймаг, нийслэлийн Засаг дарга, Тамгын газар

1. Монгол улсын Засгийн газрын 2011 оны 108-р тогтоолоор батлагдсан “Халдварт Овчинтэй Тэмцэх Үндэсний Хотолбор”-ийг хэрэгжvүлэх ажлын товлороог Эрvүл Мэндийн Газар, Мэргэжлийн хяналтын албатай хамтран боловсруулж, хэрэгжилтэнд хяналт тавих.

2. Баталгаажилтгvй хvнсний бvтээгдэхvүнийг ил задгай гудамж талбайд эрvүл мэндийн vзлэг шинжилгээнд хамрагдаагvй иргэдийн гар дээрээс худалдаалахыг таслан зогсоох.

3. Сургууль, цэцэрлэгийн нягтралыг багасгах, эрvүл ахуйн норм, нормативийг мөрдvүлэх.

4. Хvн амыг унд, ахуйн хэрэгцээний цэвэр усаар хангах, товлорсон ус хангамжийн усны эх vүсвэрийн орчинд 100 метрээс доошгvй зайд эрvүл ахуйн бvс тогтоох.

5. Орчны болон хөрсний бохирдлыг багасгах, хог, бохир усыг ил задгай асгахгvй байх, хур хог хаягдлыг зайлуулах ажлыг тогтмол хийж, хяналт тавих.

6. Дэвсгэр нутгийнхаа хvн амын дунд бvртгэгдэж байгаа вирустгепатит овчний тархалтын шалтгаан, нолоолж буй хvчин зvйлд эрvүл мэндийн байгууллагын дvгнэлт гаргуулж, овчлолийн байдал, тэмцэх, сэргийлэх талаар авч хэрэгжvүлж байгаа арга хэмжээг Иргэдийн хурлаар авч хэлэлцэн, таслан зогсоох талаар дорвитой ажил зохиох.

7. Гэдэсний халдварт овчнийг оношлох, эмчлэн сэргийлэхэд шаардагдах эм, урвалж бодис оношлуур, голомтын ариутгал халдваргвйтгэл, шавьж мэрэгч устгал, сургалт сурталчилгааны тосовлосон зардлын зарцуулалтанд хяналт тавих.

8. Халдварт овчинтэй тэмцэх, сэргийлэх ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх.

Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар

1. Гэдэсний халдварт овчинтэй тэмцэх, сэргийлэх ЭМНХС-ын 1999 оны 309 тоот, ЭМС-ын 2002 оны 198 тоот, 2010 оны 102 тоот тушаалын заалтыг хэрэгжүүлэн ажиллах.

2. Гэдэсний халдварт овчин ихсэж байгаатай уялдуулан урьд нь хвргүүлсэн заавар зовломжийн дагуу овчний сэжигтэй хvvхдvvдийг нэг бүрчлэн эмчийн vзлэгт оруулж, эмнэлгийн тусламж вйлчилгээ голомтын арга хэмжээг цаг алдалгвй шуурхай авч хэрэгжvvлэх.

3. Балнадын нян тээгч, урьд омно нь балнадаар овчлогсдийн судалгааг шинэчлэн гаргаж, хяналтанд авах.

4. Айл орх, албан байгууллагыг шаардлага хангасан жорлон, бохирын цэгтэй болгох дэс дараалсан арга хэмжээг авч, шавьж, ялаа авгалдайн устгалыг чанартай зохион байгуулах.

5. Овчлолийн байдалд дvн шинжилгээ хийж, засаг захиргааны байгууллагадаа мэдэгдэж, усан хангамж, ус, хорс, хvнсний аюулгвй байдлыг хангуулах асуудлыг тавьж шийдвэрлvvлэх.

Аймаг, нийслэлийн Боловсролын газар

1. Сургууль, цэцэрлэгийг хвчин чадалд нь тохирсон хvvхэдтэй байлгах.

2. Хvvхдийн эрvvл мэндийн байдалд эмч, багш нар одор бvр ажиглалт хийж, халдварт овчний сэжигтэй вeд хvvхдийг цэцэрлэг, хичээлээс чолоолж, орхийн эмчид vзvvлэх, овчтэй хvvхэдтэй хавьтал болсон хvvхдvvдэд эмчийн vзлэгийг заавал хийлгэх.

3. Цэвэр усны хангамжийг нэмэгдvvлэх/угаалтуур, суултуурын тоог нэмэгдvvлэх/

4. Хvvхдийн байгууллагын ариутгал, халдваргvйтгэлийн бодис цэвэрлэгээний материалын хангамжийг сайжруулах.

5. Гал тогооны ариун цэвэр эрvvл ахуйн шаардлагыг чанд мордож аяга тавгийг зов угааж, шарах, буцалгах, жигнэх аргаар ариутгах.

6. Халдваргvйтгэл, шавьжгvйтгэлийг хийлгэх.

7. Хvvхдийн байгууллагын орчны ариун цэврийг сайжруулж, хатуу хог хаягдлыг тагтай саванд хийх, орчиндоо сар бvр цэвэрлэгээг хийх.

8. Хvvхдийг цэвэр, аюулгvй, баталгаатай хоол хvнс, ундны усаар хангаж байгаад хяналт тавих.

9. Хvvхдийн байгууллагын захирал, эрхлэгч, эмч, багш, туслах багш, нийгмийн ажилтан, vйлчлэгч нарт А вируст гепатит, цусан суулга, хоолны хордлогот халдвар, энтеровируст цэврvт тууралт бvхий стоматит овчний вeд хvvхдийн байгууллагаас авч хэрэгжvvлэх арга хэмжээ, халдваргvйтгэлийн бодисыг найруулах, хэрэглэх халдвар хамгааллынталаармэдлэгийг сайжруулахсургалтыг ажлын байранд зохион байгуулах.

Халдварт Овчин Судлалын Үндэсний Тов

ИНТЕРНЕТ МЭДЭЭ

Шувууны томуугийн халдвар □ □ 2011.10.10

Индонез улсын Эрүүл мэндийн яамнаас шувууны томуугийн А/Н5N1/ вирусын халдварын хүний овчлолийн тохиолдол бүртгэгдсэн талаар мэдээлэв. Баруун Жакарта мужид амьдардаг 1 настай эмэгтэй хvvхэд 8 дугаар сарын 8-ны одор шинж тэмдэг илэрч, 15-ны одор эмнэлэгт хэвтэн, 25-ны одор нас баржээ.

Тус улсад 2006 оноос хойш шувууны томуугийн халдварын 179 тохиолдол батлагдснаас 82.1% нь нас баржээ.

Мэдээллийн эх vvcсвэр: who.int

Сальмонеллёзын дэгдэлт □ □ 2011.10.19

ОХУ-ны Братскед 40 гаруй хvvхэд гэдэсний цочмог халдвар сальмонеллёзын улмаас эмнэлэгт хэвтжээ. Урьдчилсан мэдээгээр, халдвар дамжсан хүчин зvйл нь орон нутгийн чихрийн цехэд vйлдвэрлэсэн эклер байж болзошгvй байна. Эклерийг бэлтгэхэд ондог ордог байна. Эдгээр хvvхдvvдэд “Гэдэсний цочмог халдвар” онош тавигдсан ба сальмонеллёзын халдвар болох нь лабораториар батлагдсан байна.

Энэ оны 10 сарын 7-ны одор Свердловск мужийн “Родничок” цэцэрлэгт мон 80 орчим хvvхэд нэгэн ижил оношоор эмнэлэгт хэвтэн эмчлvvлсэн байна.